# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2022 оны 05 сарын 11 өдөр Дугаар А/117 Мандалговь

"Ижий говь төсөл хөтөлбөр /Дундговь/-ийн
тоног төхөөрөмж ажлыг хүлээн авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журамын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Ижий говь төсөл хөтөлбөр /Дундговь/ ажлын хүрээнд нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Комиссын дарга: | М.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга) |
| Гишүүд: | Ж.Түмэндэлгэр (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах мэргэжилтэн) |
| | С.Ариунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Э.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Н.Энхмарт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч) |
| | Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын Аялал жуулчлал, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн) |
| | А.Мөнх-Эрдэнэ (Байгаль орчин аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн) |
| | Н.Гэрэлмаа (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Мөнхнасан (Хоббизоон ХХК-ийн менежер) |

2. "Ижий говь төсөл хөтөлбөр /Дундговь/ ажлын хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмж хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (М.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

4822150273